



### НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2002 оны 3 сарын 18 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

#### НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДҮРМИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, Автозамын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6.1.1 дүгээр заалт, 5 дугаар бүлгийн 18.3, 18.5 дугаар заалт, Засгийн газрын 2002 оны 08 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харъяа "Нийслэлийн зам, тээврийн газар" –ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Автозам замын байгууламжийг шинээр барих болон өргөтгөл шинэчлэлт хийх захиалагчийн үүргийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, хотын замын сүлжээ, замын байгууламжийн засвар, арчлалт, хамгаалах ажлыг хариуцаж зохион байгуулах үүргийг Нийслэлийн зам, тээврийн газарт тус тус хариуцуулахаар шийдвэрлэсүгэй.

Гурав. "Нийслэлийн зам, тээврийн газар"-ын бүтэц, орон тоог тогтоож, дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн ажлын алба /Т.Бадамжунай / -нд үүрэг болгосугай.

Дөрөв. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хотын ерөнхий менежер /Т.Бадамжунай /-т үүрэг болгосугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Тээврийн газар"-ын дүрмийг баталсан Нийслэлийн Засаг даргын 2001 оны 36 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

*(Handwritten signature)*  
М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2002 оны  
87 дугаар захирамжийн хавсралт

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН ХАРЬЯА ЗАМ, ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн харьяа Зам, тээврийн газар /цаашид "газар" гэнэ / нь нийслэлийн авто зам тээврийг хөгжүүлэх талаар Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, чиглэлд тусгагдсан бодлого, удирдамжийг хэрэгжүүлэх, хотын автозам, замын байгууламж, түүний засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалт болон нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавьж зохицуулах үүрэг бүхий өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар, Хотын захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд ажиллах Улсын Үйлдвэрийн Газар мөн.

1.2. Газрын үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компаний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

#### 1.3. Газрын зорилго нь:

а/ Улаанбаатар хотын оршин суугчдын нийтийн тээврийн үйлчилгээний эрэлт, хэрэгцээг хангаж, хэрэглэгчдийнхээ эрх ашгийг дээдэлсэн нийтийн тээврийн тогтвортой системийг бий болгох, салбарын хүрээнд төр, нийслэлийн засаг захиргааны байгууллагын тавьсан чиг бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэх, нийтийн тээврийн үйлчилгээг зохион байгуулж, хянаж шалгах, нийтийн тээвэр эрхлэгч өмчийн олон хэвшлийн аж ахуйн нэгжүүд зохих шаардлагыг хангаж, чөлөөтэй өрсөлдөх нөхцлийг бүрдүүлэх, тэднийг мэргэжлийн өндөр чадвартай, хүлээсэн үүргээ соёлч, шуурхай, чанартай биелүүлдэг болгон хөгжүүлэх явдал юм.

б/ Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх, авто зам, замын байгууламжийг өргөтгөн шинэчлэх, засварлах, арчлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, замын санг бүрдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж зарцуулалт, гүйцэтгэлд нь захиалагчийн хяналт тавих явдал юм.

1.4. Газрын орлого нь нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр тээврийн үйлчилгээний бүртгэл хяналт, зохицуулалт хийсний хөлс болон авто замын хуулийн хэрэгжилтэнд тавих төрийн хяналтанд зориулсан хөрөнгө, зам барилга засвар шинэчлэлтийн ажлын техник хяналтын зардал, хотын доторх зам талбайн түрээсийн төлбөр, бусад ажил үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

1.5. Газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээд мөн.

1.6.Газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас болон банкны харилцах данстай байна.

1.7.Газар нь Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Нийслэлийн төр захиргааны 3 дугаар байрны 11 давхарт байрлана.

### **Хоёр. Удирдлага зохион байгуулалт**

2.1.Газрын даргыг Ерөнхий менежерийн саналыг харгалзан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

2.2.Газрын орлогч даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга томилж, чөлөөлнө.

2.3. Газар нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, түүний Ажлын албаны удирдлага дор ажлаа явуулж тайлагнана

2.4.Газрын дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, бүтэц, орон тооны хязгаарыг Ерөнхий менежер тогтоон хяналт тавина.

2.5.Газрын дарга нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба ажилтнуудыг томилж, чөлөөлнө.

2.6.Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод ашиглаж, эзэмшинэ.

2.7.Газрын зорилт, чиг үүрэгтэй холбогдсон асуудлыг хэлэлцэх, зөвшилцөх үүрэг бүхий даргын дэргэдэх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн гишүүд гагцхүү зөвлөх эрхтэй байна.

2.8.Газрын даргын эрх, үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг нийслэлийн Өмчийн газар, үйл ажиллагааны чиглэлээр Ерөнхий менежер гэрээ байгуулан ажиллана.

### **Гурав. Газрын үүрэг**

3.1. Улаанбаатар хотын авто замын сүлжээг хөгжүүлэх, авто зам, замын байгууламжийн засвар арчлалт, хамгаалалт хийх, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийж, иргэдийн тээврийн эрэлт хэрэгцээг хангах, тээврийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх асуудлаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

3.2. Хотын дотор, хот орчмын нийтийн тээврийн үйлчилгээнд тээврийн аж ахуйн нэгжүүд чөлөөтэй өрсөлдөх орчин бүрдүүлэх, тэдгээрийг тээвэрлэлтийн ажил үйлчилгээний чанар, мэргэжлийн ур чадвар, боловсон хүчний чадавхи зэрэг үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулж нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, аттестатчилж байх ажлыг нийслэлийн Засаг даргын эрх олгосны дагуу гүйцэтгэнэ.

3.3. Хотын зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэхэд дотоодын хөрөнгө болон гадаадын зээл, хандивлагч байгууллагуудын тусламжтайгаар хэрэгжүүлэх төслүүдийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулан холбогдох байгууллагад оруулах, төслийн хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, төслийг захиалж хэрэгжүүлэхэд оролцох.

3.4. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр автозам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалт, хайгуул зураг төслийн ажил эрхлэх аж ахуйн байгууллагад тусгай зөвшөөрөл олгоход санал өгч, авто замын салбарт зах зээлийн харилцааг төлөвшүүлэх, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдийг шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5. Нийслэлийн нийтийн тээврийн автобус, троллейбус таксийн тээврийн үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэхээр чиглэл, маршрут шинээр нээх, өөрчлөх график, цагийн хуваарийг тогтоох, шинэчлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулан ажиллана.

3.6. Нийслэлд баригдсан автозам, замын байгууламжийг ашиглалтанд хүлээн авч, нэгдсэн данс бүртгэлд тусган пастортжуулан мэдээллийн сан байгуулж, шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагуудад тухай бүр гаргаж өгч байх, замын эвдрэлээс шалдтгаалж гарсан зам тээврийн ослын судалгаа, замын хөдөлгөөний эрчмийн тооллого хийж төлөвлөлтөнд ашиглана.

3.7. Автозам, замын байгууламжийн засвар арчлалт хийх, түүний материаллаг баазыг бэхжүүлэхэд захиалагчийн хяналт тавьж, түүнийг чанартай гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх, байнгын ашиглалтад хүлээн авах, цаашид арчлан хамгаалагчийг тогтоох, тэдгээр ажлын зардлын бүтцэд шинжилгээ хийх болон технологийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, санал төсөл боловсруулна.

3.8. Зам, тээврийн сүлжээний төлөвлөлтийн болон автозам, замын байгууламжийг засварлах арчилж хамгаалахтай холбогдсон стандарт, норм, нормативийг хот төлөвлөлтийн болон байгаль орчин, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангахуйцаар боловсруулж, зохих журмын дагуу батлуулан, биелэлтэнд нь хяналт тавьж хэрэгжүүлнэ.

3.9. Иргэдийн ахуйн тээврийн болон захиалгат үйлчилгээг зохион байгуулалтанд оруулж, ажил үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих, мэргэжлийн удирдлагаар хангана.

3.10. Нийслэлийн замын засвар арчлалт, нийтийн тээврийн төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдэнтэй дараах хэлбэрээр харьцана.

а/ Төрийн өмчит замын засвар арчлалтын болон автобус, троллейбусны компаний захирлыг ажилд томилох чөлөөлөх, цалин тогтоох асуудлыг төлөвлөж захирагчийн ажлын албаар батлуулах ба орлогч, ерөнхий инженерийг ажилд томилох, чөлөөлөх болон захирлуудад шагнал урамшил олгох асуудлыг газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

б/. Компаниудын материаллаг баазыг бэхжүүлэх, техник технологи, хөдлөх бүрэлдэхүүнээр хангах, хувьчлах асуудлыг төлөвлөн шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

в/ Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг компаниудын дүрэм, бүтэц зохион байгуулалтыг батлаж, ажиллах цагийн хуваарь, цаг, рейсийн болон орлогын төлөвлөгөөг батлаж мөрдүүлэх, орлого, зарлагын тайлан балансыг улирал тутам авч нэгтгэн судалгаа шинжилгээ хийж чиглэл удирдамж өгнө.

г/ Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, болон сэлбэг хэрэгсэл, шатахуунаар хангах, гадаад оронд туршлага судлах, суралцах ажлыг нэгтгэн зохион байгуулах, энэ асуудлаар гадаадад ажиллах захирал, орлогч дарга, ерөнхий инженерт томилолт олгох, дүгнэж ажиллана.

д/ Зам, тээврийн сүлжээний ажил үйлчилгээний байдал, цаг үеийн асуудлаар сард 2 удаа шуурхай зөвлөгөөн зохион байгуулах, үүрэг даалгавар өгөх, дүгнэх

3.11. Улаанбаатар хотын автозам, нийтийн тээврийн сүлжээг боловсронгуй болгох мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, салбарын бүтэц зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх Нийслэл хотын нийтийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, шинэтгэх талаар санал, төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахад оролцоно.

3.12. Замын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн автозам, замын байгууламжийг барьж байгуулах тооцоо судалгаа, техник эдийн засгийн үндэслэл, хайгуулын ажлыг зураг төслийн төлөвлөгөөнд тусгуулан, урьдчилан боловсруулж байна.

3.13. Хотын ерөнхий төлөвлөгөө, автозамын сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг үндэслэн тухайн нутаг дэвсгэр, хорооллын замын сүлжээний нарийвчилсан төлөвлөлт боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.14. Нийслэлийн нутаг дэвсгэр дээрх автозам, замын байгууламжинд жил бүр тогтоосон журам, технологийн зааврын дагуу үзлэг явуулж, засвар арчлалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

3.15. Тухайн жилийн замын сангийн хөрөнгийн хуваарилалтын талаар санал боловсруулж замын зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр Засаг даргад өргөн барих, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулна.

3.16. Нийслэлийн замын санг бүрдүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, зарцуулалт гүйцэтгэлд хяналт тавина.

3.17. Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээний шугам, чиглэл бүрээр орлого, зардлын тооцоог хийж, нийгмийн шаардлагаар зайлшгүй алдагдалтай ажиллах чиглэлийн алдагдлыг нөхөх асуудлыг боловсруулж Нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлнэ.

3.18. Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон замын сангийн задалгааны талаар тооцоо судалгаа хийж холбогдох газруудад оруулан шийдвэрлүүлэх, замын сангийн зөвлөлтэй хамтран замын санг төвлөрүүлэн хуваарилах зарцуулалтад хяналт тавих, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь гаргаж өгнө.

3.19. Хотын доторх зам барилгын болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санхүү эдийн засаг, үйл ажиллагааны мэдээ тайланг нэгтгэн судалгаа дүгнэлт хийж; үйл ажилагааг нь

мэргэжлийн төвшинд хүргэх механизм бүрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.20. Автозам, замын байгууламжийн барилга засвар арчлалтын болон нийтийн тээврийн үйлчилгээ, материаллаг бааз, боловсон хүчний хангалт, үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээллийн сан бий болгох, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зам, тээврийн сүлжээтэй холбогдолтой мэдээ, мэдээлэл, шинэ технологи, хууль тогтоомж, норм норматив, стандарт, олон улсын гэрээ хэлэлцээр, конвенци зэрэг мэдээллээр хангаж, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, тээврийн мэдээ, мэдээллээр үйлчилнэ.

3.21. Хотын тээвэр авто замын салбарын аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээг тодорхойлж, зам барилга, засвар арчлалтын ажил, нийтийн тээврийн болон авто үйлчилгээ эрхлэгчдийг мэргэшүүлэх мэргэжлийн зэргийг дээшлүүлэх семинар сургалт зохион байгуулах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө тусламж үзүүлнэ.

3.22. Автобус, таксийн тээврийн автовокзал, буудал зогсоол байгуулах санал, асуудал боловсруулж шийдвэрлүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэнэ.

3.23. Нийтийн тээврийн үйлчилгээнд хяналт тавих, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хотын доторх замын хөдөлгөөний чиглэл тогтоох, замын аюулгүйн зурвас дээр гарц гаргах, замын үзэгдэх орчинг хангах, шинээр авто замын орц, гарц байгуулах, замын гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэгээ байгуулахад мэргэжлийн байгууллагын зүгээс санал өгөх, автобусны буудал зогсоол, тээврийн хэрэгсэлд байрлуулах чиглэл, маршрутын зураглал, хаяг, дугаар зэрэг үйлчилгээний мэдээллийг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулна.

3.24. Зам, тээврийн талаар мөрдөж байгаа хууль тогтоомжийг хэрэгжүүлэх түүнтэй нийцүүлэн гаргасан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр болон зам барилга засвар, арчлалтын норм норматив, тээвэр ашиглалтын дүрэм журам, үйлчилгээний стандарт, норм нормативын биелэлтийг хангах хотын нутаг дэвсгэр дэх автозамын болон тээвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хийх захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, бүртгэл хяналтыг орчин үеийн техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна.

3.25. Нийтийн тээвэр эрхлэн гүйцэтгэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй ажил үйлчилгээний гэрээ байгуулсны үндсэн дээр тэдгээрийн цагийн хуваарь, графикийн биелэлтэнд хяналт тавьж, шуурхай зохицуулалтаар удирдан чиглүүлнэ.

3.26. Замын эвдрэл саатлаас болж нийтийн тээврийн үйлчилгээний шугамын цагийн тасалдалд учруулсан хохирлын хэмжээг тогтоох, барагдуулах арга хэмжээг авч ажиллана.

3.27. Нийтийн тээврийн үйлчилгээний талаархи иргэдийн санаа бодлыг судалж, хүсэлт гомдлыг шуурхай барагдуулах, дэмжлэг үзүүлэх, улмаар төр захиргааны байгууллагуудтай харилцан холбоотой ажиллана.

3.28. Зам барилгын ашиглалтын болон нийтийн тээврийн үйлчилгээнд зориулан машин механизм тээврийн хэрэгслийг импортоор оруулах аж ахуйн нэгж

иргэдтэй тээврийн хэрэгслийн техникийн болон ашиглалтын үзүүлэлт, ажил үйлчилгээ эрхлэх талаар урьдчилан тохиролцож байна.

3.29. Нийслэлийн нийтийн тээврийн зориулалттай хөдлөх бүрэлдэхүүний паркийн бүтцийг оновчтой болгох, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, техник ашиглалтын шаардлагад илүү нийцтэй, эдийн засгийн хэмнэлттэй тээврийн хэрэгслийг сонгож ашиглах санал боловсруулж хэрэгжүүлэх, мөрдөх стандарт, норм норматив, жишиг үнэ тарифын үндэслэл боловсруулж зохих газраар шийдвэрлүүлнэ.

3.30. Нийслэлийн хэмжээнд автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг зохион байгуулж явуулах болон авто үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийх, аттестатчлал явуулна.

3.31. Хэрэглэгчийн болон оршин суугчдын эрх ашгийг хамгаалах үүднээс шатахуун, автомашины сэлбэг хэрэгсэл тослох материалын чанар болон аж ахуйн нэгжүүдийн техник, технологийн шаардлага, үйлчилгээний байдалд холбогдох газруудтай хамтран шалгалт хийж арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна.

3.32. Нийслэл хотод орж гарч байгаа тээврийн хэрэгсэлийн ашиглалт, үйлчилгээний байдалд хяналт тавьж шалган бүртгэх товчоодын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж, зохион байгуулна.

3.33. Хэрэглэгчдийн болон авто тээвэр эрхлэгчдийн нийтлэг эрх, ашгийг хамгаалсан төрийн бус байгууллагатай зам тээврийг хөгжүүлэх, зохих төвшинд хүрсэн мэргэжлийн авто аж ахуйн нэгжийг бэхжүүлэх, тогтвортой хөгжлийг хангаж, үйлчилгээний соёл, чанарыг дээшлүүлэх, хөндлөнгийн болон өөрийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр, хамтран ажиллаж, харилцан туслалцаа үзүүлнэ.

3.34. Хотын замын сүлжээг хөгжүүлэх, нийтийн тээврийн талаар олон улсын байгууллага, гадаад орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, Монгол улсын нэгдэн орсон конвенциэр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

3.35. Тээврийн үйлчилгээнд дангаар ноёрхох явдлыг хязгаарлаж өрсөлдөөн өрнүүлэх замаар хотын нийтийн тээврийн үйлчилгээний үнэ тарифыг, зах зээлийн харилцаа, төрийн бодлоготой уялдуулан, тогтвортой уян хатан байлгах бодлогыг хэрэгжүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаална.

3.36. Нийслэлийн хэмжээнд тээврийн ажил үйлчилгээ эрхлэгчид болон тээврээр үйлчлүүлэгч нарт хэрэглэгдэх зөвшөөрөл, гэрчилгээ, үнэмлэх зэрэг бичиг баримт болон зорчигчдын тасалбар, байнгын билет зэрэг үнэт цаасыг батлагдсан загварын дагуу нэгдсэн журмаар хэвлүүлж хангах, тэдгээрийн ашиглалт зарцуулалтанд хяналт тавина.

3.37. Зам, тээврийн сүлжээг хөгжүүлэх, боловсон хүчнийг сургаж мэргэшүүлэх зэрэг асуудлаар бусад орны туршлагыг судлах, хамтран ажиллах гадаад харилцааны чиг бодлогыг тогтоож, хэрэгжүүлнэ.

3.38. Зам, тээврийн сүлжээний үйл ажиллагааны талаарх мэдээллийг нэгтгэн холбогдох газарт өгөх, гарч байгаа ололт амжилт, зөрчил дутагдал, өөрчлөлтийн тухай нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг зохион байгуулна.

3.39. Нийтийн тээвэрлэлтийн болон автозам, замын байгууламжийн засвар арчлалтын ажил, үйлдвэрлэлийн осол зөрчлын галын аюулаас урьдчилан

сэргийлэх, хөдөлмөр хамгаалал хангах талаар арга зүйн туслалцаа үзүүлж, энэ талаарх хууль тогтоомж, заавар, журмын биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлэх.

3.40. Хотын автозам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын талаар Замын цагдаа бусад байгууллага, албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллана.

3.41. Замын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг хуулийн дагуу арга хэмжээ авахуулахаар эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

3.42. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хүрээнд авто тээврийн ашиглалт, нийтийн тээврийн үйлчилгээний талаарх хууль тогтоомж, нийслэлийн удирдлагын шийдвэрийн биелэлтийг хангуулах, зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулж, хохиролыг арилгуулна.

**Дөрөв. Газрын эрх**

4.1. Газрын өмч хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэмд нийцүүлэн эзэмшин, ашиглаж, захиран зарцуулна.

4.2. Авто зам, тээврийн салбарын холбогдолтой асуудлаар нийслэлийн Засаг дарга болон Дэд бүтцийн сайдтай зөвшилцөн хамтарсан шийдвэр гаргуулж хэрэгжүүлэх.

4.3. Зам, тээврийн ажил үйлчилгээ эрхлэгчдэд бүртгэл хяналт, шалгалт зуучлал, зөвшөөрөл олгох зэргээр ажил үйлчилгээ үзүүлснийхээ төлбөр тогтоож гэрээний дагуу хураамжийг авна.

4.4. Газрын хариуцах асуудлаар гадаад орны болон өөрийн улсын холбогдох байгууллагатай бие даан харилцах, Нийслэлийн Засаг даргын болон холбогдох эрх бүхий байгууллагын эрх олгосны дагуу гэрээ хэлцэл хийж, хамтран ажиллана.

4.5. Автозам, замын байгууламжийн барилга, засвар арчлалтын болон үйлдвэрлэлийн баазын өргөтгөл, шинэчлэлийн ажлын зургийн даалгавар боловсруулан, зураг төсөлд шүүлт экспертиз хийж батлах.

4.6. Хотын дотор авто тээврийг хөгжүүлэх, үйлчилгээний бүртгэл, хяналт зохицуулалтанд шинэ техник технологи нэвтрүүлэх, чиглэл, төсөл, техник эдийн засгийн үндэслэлд экспертиз хийж санал дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулна.

4.7. Хотын зам, нийтийн тээврийн салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг хувьчлах, нэгтгэн нийлүүлэх, шинээр бий болгох, татан буулгах, тэдгээрийн үйлдвэрийн баазыг өргөтгөн бэхжүүлэх технологийн тоног төхөөрөмж, машин техникийг шилжүүлэх, устгах зэрэг асуудлуудын талаар санал дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

4.8. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тусгай зөвшөөрөл олгох, ажил үйлчилгээний гэрээ, тусгай зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд түүнийг хүчингүй болгоно.

4.9. Улаанбаатар хотын хэмжээнд зам, тээврийн сүлжээг шинэчлэн өөрчлөх, хотын тээврийн үйлчилгээг хүн амд ойртуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг



хангах зорилгоор үйлчилгээний чиглэлийг өөрчлөх, шинээр нээх, хаах талаар санал боловсруулж шийдвэрлүүлнэ.

4.10. Зам, тээврийн төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагуудын эрх баригчдад төрийн өмчийг хүлээлгэн өгч эзэмшүүлэх, тэднийг ажилд томилох, чөлөөлөх болон иргэний гэрээнд тусгах эрх, үүрэг хариуцлага зэрэг асуудлаар төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч холбогдох байгууллагад саналаа өгөх.

4.11. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр газар нь өөрийн салбар нэгжийг байгуулан ажиллуулж болно.

4.12. Нийслэлийн өмчийн автозам, замын байгууламжийг нэгдсэн данс бүртгэлдээ тусган авах, данснаас хасах, харьяаллыг нь өөрчлөн өөр байгууллага хувь хүнд эзэмшүүлэх санал тавих

4.13. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт Авто замын болон авто тээврийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, хариуцлагыг тооцон ажиллана.

4.14. Хувьчлагдсан үйлдвэр байгууллагуудаас тэдгээрийн гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаатай танилцаж, материал техникийн хангамж, боловсон хүчний сургалт, шинэ техник технологи нэвтрүүлэх зэрэг ажлыг зохион байгуулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, хууль тогтоомж зөрчсөн буруутай үйл ажиллагаа илэрвэл түүнийг арилгуулах арга хэмжээ авах.

4.15. Автозам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг батлагдсан зураг төсөл технологийн горим зөрчсөн, чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд буруутай этгээдийн зардлаар дахин хийлгэх ба зөрчил дутагдлыг арилгуулах барилгын ажлыг зогсоох арга хэмжээ авна.

4.16. Хотын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн хотын доторх автозамын зэрэглэлийн дагуу замын сүлжээний хяналт тавих зурвас буюу замын улаан шугамыг нарийвчлан баримталж, энэ дагуу барилгажилтанд хяналт тавин зөрчлийг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.

4.17. Замын сангийн, төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр нийслэлд зам, замын байгууламжийн өргөтгөл шинэчлэлт хийх болон түүний засвар, арчлалт, хамгаалалтын ажлыг захиалан хийлгэнэ

4.18. Хотын барилга хот байгуулалтын мэргэжлийн комиссын бүрэлдэхүүнд газрын удирдлага орж газар олгохоор төлөвлөж буй саналууд, төрөл бүрийн инженерийн шугам сүлжээг төлөвлөх, шинээр байгуулах авто зам, зогсоол, нийтийн тээврийн буудлын байршилтанд зам тээврийн сүлжээний төлөвлөлттэй уялдуулан санал өгч ажиллана.

4.19. Автозам, замын байгууламжаар даац хэтэрсэн, зөвшөөрөгдсөнөөс илүү овор хэмжээтэй буюу тусгай хамгаалалтгүйгээр гинжит дугуйтай тээврийн хэрэгслээр зорчих зөвшөөрөл олгоно.

4.20. Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх төрлийн инженерийн шугам сүлжээний барилгын ажил гүйцэтгэх үед хотын зам, талбайг эвдэж устгасны нөхөн төлбөр, нөхөн сэргээх ажлын зардлыг тухайн ажлын төсөвт тусгуулж хотын замын санд төвлөрүүлэн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

4.21. Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, бэрхшээлээс шалтгаалан авто зам замын байгууламжинд эвдрэл саатал гарч түргэн засварлах шаардлага гарсан үед нийслэлийн аж ахуйн нэгж, байгууллага иргэдээс тээвэр холбооны хэрэгсэл эд хөрөнгийг нөхөн олговортойгоор гаргуулах болон автозам, замын байгууламжийг хэвийн байдалд оруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

4.22. Нийтийн тээвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдтэй хийсэн гэрээний биелэлт, тээврийн үйлчилгээний чанар, соёлч шуурхай байдал, зөрчил доголдол, хариуцлага сахилга батад хяналт шалгалт явуулж илэрсэн дутагдлыг арилгуулан хариуцлага тооцож, ажил үйлчилгээ эрхлэх, гэрээг цуцлах, олгосон тусгай зөвшөөрлийг хураан авах, гэрээг цуцлах арга хэмжээ авна.

### **Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт**

5.1. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлнө.

5.2. Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.3. Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.4. Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.5. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.6. Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.7. Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баримтална

### **Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах**

6.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч өөрийн эрх мэдлийн хүрээнд газрыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

### **Долоо. Хариуцлага**

7.1. Газрын албан хаагчид нь байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

7.2. Монгол улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон хотын Захирагчийн шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу харицлага хүлээнэ.

7.3. Газрын захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагадаа хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

### **Найм. Бусад**

8.1. Энэхүү дүрмэнд нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.